

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАГА
ХАЙЛААСТЫН ДООД ХЭСЭГ, АР НАЙМГАНЫ ХӨНДИЙН ДУНД
ХЭСГИЙН БАРУУН САЛАА ЖАЛГА-2” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН
ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021068
Регистрийн дугаар: 5935539*

Хянасан:

УАӨЯ-ны ХБОБНУГазрын ахлах мэргэжилтэн:Ц.Жаргалнэмэх

Төв аймгийн БОАЖГазрын ахлах мэргэжилтэн:С.Эрдэнэцогт

Биелэлтийг тайлагнасан:

“Заамар Гоулд” ХХК-ний ерөнхий захирал:.....С.Энхтулга

“Заамар Гоулд” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн:.....Н.Гончигмаа

Агуулга

1. ОРШИЛ	3
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
14. ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙГДЭХ АЖИЛ БОЛОН ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	21

Зургийн жагсаалт

Зураг 1 Талбайн байршлын тойм зураг	5
---	---

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол	4
Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	13
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
Хүснэгт 5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	20
Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
Хүснэгт 9 БОМТ хэрэгжилт тайлагнах	21
Хүснэгт 10 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	22

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1 Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтууд
Хавсралт 2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл
Хавсралт 3 Улсын бүртгэлийн гэрчилгээ
Хавсралт 4 БОМТ-ний биеллэтийн дүгнэлтийн хуудас
Хавсралт 5 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний дэсгэр зураг

1. ОРШИЛ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-021068 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь дахь “Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2”-ны алтны шороон ордын 2026 оны ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчныг хамгаалах, менежментийн төлөвлөгөөг ордын талбайд 2025 онд гүйцэтгэсэн нэмэлт геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, 2026 онд батлуулсан Техник эдийн засгийн үндэслэл зэрэг материалыг үндэслэн боловсруулав.

“Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2”-ын алтны шороон ордын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах дараах арга хэмжээнүүдийг дагаж ажиллана.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргэсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

“Заамар Гоулд” ХХК нь 2026 оны 08 дугаар сараас эхлэн бэлтгэл ажлуудыг хангаж ажиллахаар төлөвлөөд байна.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2 нэртэй MV-021068 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ нь 921.7 га юм. Улаанбаатар хотоос баруун хойш 210 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 25 км, “Шижир алт” суурингаас 20 км зайд, байр зүйн зургийн М-48-137, 138 нэрэлбэрт оршдог. Төслийн талбай руу жилийн аль ч улиралд автомашинаар зорчих боломжтой юм.


2018 онд гүйцэтгэсэн Жалга-2 алтны шороон ордыг ЭМБЗ-ийн 2019.04.15 өдрийн н/34 дугаартай дүгнэлтэд геологийн нөөц химийн цэврээр бодитой (В) зэрэглэлээр 26.6 кг, боломжтой (С) зэрэглэлээр 4.054 кг, нийт В+С зэрэглэлээр 30.72 кг-аар тогтоогдсон байдаг. Тус нөөцийг 2025 оны нэмэлт хайгуулын ажлаар хүчингүйд тооцож, шинээр нөөцийг тодотгосон байна. Бага Хайлаастын доод хэсгийн орд нь Бага Хайлаастын хөндийн доод хэсэгт V хэлбэрийн хөндийн дагуу сунаж тогтсон гидрогеологи, уул-техникийн тааламжтай нөхцөлд оршино. Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2 орд нь хөндийн баруун эрэг дагууд сунаж тогтсон, гидрогеологи, уул-техникийн тааламжтай нөхцөлд орших

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

бөгөөд нэмэлт хайгуулын өрөмдлөгөөр уст үе, давхарга тогтоогдоогүй байна. Иймд дээрх ордуудыг өмнөх олборлолтын туршлага болон уул геологийн тогтцоос хамааран угаах төхөөрөмжийн тусламжтайгаар ангилан олборлох аргаар олборлоход тохиромжтой байна. Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбицлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол

№	град	мин	сек	град	мин	Сек
1	104	29	54.57	48	19	34.82
2	104	30	4.02	48	19	18.82
3	104	29	45.93	48	19	31.81
4	104	29	41.93	48	19	29.8
5	104	30	19.01	48	19	3.82
6	104	30	19.01	48	19	3.82
7	104	29	56	48	19	3.82
8	104	29	56	48	18	4.28
9	104	29	46.04	48	18	4.28
10	104	29	46.04	48	17	44.82
11	104	29	25.85	48	17	44.82
12	104	29	25.85	48	17	45.46
13	104	29	16.61	48	17	45.46
14	104	29	16.61	48	17	46.61
15	104	29	6.68	48	17	46.61
16	104	29	6.68	48	17	44.82
17	104	29	0.94	48	17	44.82
18	104	29	0.94	48	17	31.81
19	104	28	40.93	48	17	31.81
20	104	28	40.93	48	18	51.8
21	104	26	50.93	48	18	51.8
22	104	26	50.93	48	19	41.81
23	104	29	57.93	48	19	41.81
24	104	29	57.93	48	19	35.8



Зураг 1 Талбайн байршлын тойм зураг

2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим


- ✓ **Ажиллах горим.** Уурхайн үйл ажиллагаа нь улирлын чанартай тул уурхайн операторууд, туслах ажилчид болон ИТА-ыг улирлын чанартай ажиллуулахаар төсөлд тусгасан.

Жил бүрийн 3-р сарын 15-ээс эхлэн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 4 сараас 9-р сарыг дуустал уулын ажил явуулахаар төлөвлөсөн боловч энэ жилийн хувьд 08 сараас бэлтгэнл ажлуудыг хангаж ажиллахаар байна. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амрахаар төлөвлөсөн.

2026 онд явагдах уулын ажил. Уурхайн нээлтийг ордын уул геологи, уул техникийн нөхцөл, цаашдын ашиглалтын төлөв зэргээс хамааруулан Бага Хайлаастын амны доод хэсэг ордын 7-В блокоос эхлүүлж байна. Энэ блокийн хуулах хөрсний зузаан харьцангуй бага байна. Технологийн шийдлийн дагуу цаашид 6-В блок руу ахихаар төлөвлөв. Нээлтийн ажлаар 7-В блокийн үржил шимт хөрсийг бульдозероор 0.3 м-ээс багагүй зузаан хуулан түрж шимт хөрсний овоолгод хураана. Уурхайг нээх уулын үндсэн малталтыг 7-В блокийн үржил шимт хөрсийг хуулсны дараа хайгуулын шугам 7-д перпендикуляраар баруун хойноос зүүн урд чиглэлд огтлогч траншей нэвтэрч хөрс хуулалтын ажлыг эхлүүлнэ. Нээлтийн ажлаар

1775 м² талбай бүхий 1.1 м зузаан элсний давхарга нээгдэх бөгөөд энэ нь угаах төхөөрөмжийг 5 хоног тасралтгүй хангах элсний нөөц бэлтгэгдэж байгаа юм

- ✓ **Үржил шимт хөрс хуулалт.** Үржил шимт хөрсийг хуулахдаа ашиглалтын тухайн жил бүрийн эхэнд хайгуулын шугамын дагууд бульдозероор 0.3 метрээс ихгүй зузаан хуулан түрж, овоолго үүсгэн хураана. Үржил шимт хөрсний овоолгыг 5 м-ээс ихгүй өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөв. Шимт хөрсний овоолгын өндөр 5 м, сул чөлөөтэй, ямар ч нягтаршуулалгүй, овоолгын гадаргуу дээгүүр автосамосвал, бульдозер гэх мэт хүнд даацын тоног төхөөрөмж явахгүй байх шаардлагыг баримтална.



- ✓ **Хөрс хуулалтын ажил.** Хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан тээвэрлэж олборлосон хэсэгт дотоод овоолго байгуулах байдлаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөв. Иймд ордын хөрсийг хуулахдаа экскаватор-автосамосвалын хослолоор ангилан олборлох аргаар уулын ажил гүйцэтгэнэ. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлт, өмнөх олборлолтын бүтээлтэй ажиллах байдал зэргээс хамааран 3.5 метр байна.

Уурхай-1. Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд хэсэгт байх Бага Хайлаастын амны доод хэсэг ил уурхай нь 740 м урт, дунджаар 80 м өргөн, 37.3 м гүн /30.4-40.3 метрийн хооронд/, нийт 8.6 га талбайг эзэлж байгаа бөгөөд уурхай нь зүүн урдаас баруун хойд зүгт чиглэлтэй сунаж тогтсон давхаргын суналын дагуу байрлана. Ашиглалтын эхний жилийн хугацаанд уурхай-1 дээр уулын ажил явагдахаар байна.

Уурхай-2. Тусгай зөвшөөрлийн талбайн урд хэсэгт байх Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2 ил уурхай нь 1350 м урт, 60 м өргөн, 22.5 м гүн /14.8-33.3 метрийн хооронд/, нийт 11 га талбайг эзэлж байгаа бөгөөд уурхай нь зүүн хойноос баруун урд зүгт чиглэлтэй сунаж тогтсон давхаргын суналын дагуу байрлана.

Ашиглалтын эхнээс хөрсний дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийг уулын ажилтай зэрэг гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь нөхөн сэргээлтийн ажлыг хөнгөвчлөх, техникийн нөхөн сэргээлтийн асар их хэмжээний зардал хэмнэх, богино хугацаанд ордыг унаган төрхөд нь ойртуулах зэрэг таатай нөлөөтэй байна. Тус шороон орд нь гүний ангилалд хамаарагдаж байгаа тул доголын өндөр, хажуугийн өнцөг зэргийг ТЭЗҮ-д заасан хэмжээсний дагуу авч уулын ажлыг явуулан ил уурхайн хажуугийн тогтворжилтыг ханган ажиллахыг төсөл захиалагчид зөвлөмж болгож байна.

Ил уурхайд ажиллах үндсэн техник, тоног төхөөрөмж, бүтээлийн тооцоо. Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглаж байгаа техникүүдийг үргэлжлүүлэн ашиглахаар тусгав.

Одоо ашиглагдаж байгаа үндсэн техник тоног төхөөрөмжүүд нь ашиглалтад ороод удаагүй 2-4 жил ашигласан тоног төхөөрөмжүүд байна. Уурхайн хөрс хуулалтын ажилд:

- CAT 395 экскаватор 2 ш
- Doosan DX800 экскаватор 1 ш
- Олборлолтын ажилд Doosan DX500 экскаватор 1ш
- Хөрс тээвэрлэлтийн ажилд Howo440 60 тонн даацтай автосамосвал 12 ш
- Элс тээвэрлэлтэд Tonly TL869 50т даацтай автосамосвал 2 ш
- Ул тааз цэвэрлэгээ болон үржил шимт хөрс хуулах, хөрсний овоолго түрэх, тэгшлэх ажилд CAT D6, CAT D8 маркийн бульдозерууд
- Угаах төхөөрөмж тэжээлээр хангах болон туслах ажилд SEM 656D маркийн 3 м3 утгуурын багтаамжтай утгуурт ачигч тус тус ажиллана.

Баяжуулах технологи. Алтны шороон ордын ашигт давхаргыг угаан баяжуулах хэсэг нь уурхайгаас тэжээх элсний хэмжээнээс хамаарч элс угаалтын ажлын хэмжээ харилцан адилгүй байна. Тус шороон ордын баяжуулах хэсгийн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэрэгтэй уялдаж ажиллана. Алт агуулагч элс угаах цех нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах бөгөөд дулааны улиралд ажиллаж, хүйтний улиралд амарна. Төслийн хугацаа 5 жил байна. Баяжуулах хэсэг нийт 2 жилийн хугацаанд 178.8 мян.м3 элс баяжуулах ба нийт ойролцоогоор 190 хоног ажиллана. Баяжуулах хэсэг нь 80 м3/цагийн хүчин чадалтай 1 ширхэг угаах төхөөрөмж ашиглана.

Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй. Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээнавах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг.

Шатах тослох материалын агуулах. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна. Түлшийг тусгайлан бэлтгэсэн талбайд 3 ш ёмкостод хадгална. Шатахуун түгээх станц болон уурхайн засварын газрын хэрэгцээт талбай 1.2 га байна. ШТМ-ын агуулахын талбайг хатуу хучилттай болгож газрын, ШТМ-ын агуулахыг галын шаардлагын дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан.

Цахилгаан хангамж. “Заамар гоулд” ХХК-ий төслийн талбайд өмнөх олборлолтын үед Дархан-Уул аймгийн цахилгаан түгээх төвийн харьяа Заамар сумын Өгөөмөр багийн 35/6.3-ийн дэд станцаас 6.3кв-ын өндөр хүчдэлийн агаарын шугам татсан бөгөөд цахилгаан эрчим хүчний асуудлаа найдвартай, бүрэн шийдвэрлэсэн байна. Уг цахилгаан дамжуулах агаарын шугамаар ордын цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид болох уурхайн хотхон, баяжуулах хэсгийг тэжээх бүрэн боломжтой. Уурхайн ашиглалтын үед цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай дараах хэрэглэгчид байна. Үүнд: -Баяжуулах хэсэг -Ил уурхай -Засварын хэсэг

Жалга-2 ордын гидрогеологийн нөхцөл: Жалга-2 орд нь усан хагалбарын орой орчмын хэсэгт гадаргуугийн хаялбарын 1170-1200 м-ийн түвшинд байгаа нь Ар Наймганы хөндийн дунд хэсэг (1060 м), Туул голын татам (920 м)-ын гадаргуугийн түвшнээс 1110-1210 м-ийн өндөрт байршина. Хайгуулын өрөмдлөгөөр ордын сэвсгэр хурдсанд уст үе илрээгүй бөгөөд ашигт давхарга нь усгүй хуурай нөхцөлд оршиж буй нь олборлолтын үеийн уул-техник, гидрогеологийн тааламжтай нөхцөлтэй бөгөөд ордын олборлох явцад карьерын мөргөцгийг хуурайшуулах шаардлагагүй юм. Талбайн өмнөд хэсэгт Жалга-2 хөндийн адагт байршиж буй “Заамар гоулд” ХХК-ийн өмнө ашиглаж буй 2.8 га талбай бүхий цэвэр, бохирын нуур, угаах төхөөрөмжийг ашиглах ба техникийн усан хангамжийг 3.0-4.0 км зайд урсан өнгөрөх Туул голын гадаргуугийн усаар сэлбэх зарчмаар шийднэ.

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2 орд нь металлогений хувьд Хойт Хэнтийн алтны бүсийн Заамарын хүдрийн дүүргийн Заамарын нурууны ар хүдрийн зангилааны Бумбатын хүдрийн талбайд (УГЗ-200 ангилалаар) орших бөгөөд өмнөх жилүүдэд тус хүдрийн дүүрэгт явуулсан 1:50000-ны масштабын эрэл зураглал, тус тусгай зөвшөөрлийн талбайд 2025 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгүүдээр сайтар судлагдсан байна.

Уул зүй: Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог.

Уур амьсгал: Уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн дотроос нарны цацраг, агаарын орчил урсгал, байгалийн газарзүйн нөхцөл чухал юм. Эдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Төв аймаг уур амьсгалын хувьд сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их агууриг 33.60С, өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун болно.

Ус зүй: Ар наймганы алтны шороон ордын талбай нь гидрогеологийн ангиллаар Хангай, Хэнтийн гидрогеологийн массивт хамаарна. Газрын доорх ус нь уулс хоорондын хөндийнүүдийг дүүргэсэн тунамал хурдас болон дунд ба эрт төрмөлийн гүний ба тунамал-метаморф чулуулгийн ан цавтай холбоотой. Газрын доорх усны түвшин газрын гадаргаас 42-44 м гүнд оршино. Ар наймганы хэмжээнд усны байгалийн нөөц 1448-1933 шоо метр хоног байна. Дөрөвдөгчийн аллювийн хурдсан дах гүний ус нь цэнгэг бөгөөд эрдэсжилт нь 0.4 г/л-с илүүгүй, устөрөгчийн ионы концентраци буюу рН 7.5-8.5, ерөнхий хатуулаг 4.3 мг.экв. Газрын доорх ус нь найрлагаараа ундны усны шаардлагыг бүрэн хангана. Туул голын газрын доорх ус нүүрсхүчлийн хий болон хүчил, сульфат, магнийн зэрэг идэмхий агуулагчгүй учир гидрогеологийн нөхцөлийн хувьд энгийн нөхцөлтөйд тооцогдоно /Хишигтогтох, 2013/.

Заамар сумын уур амьсгал, цаг уурын үзүүлэлтүүд

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Төв аймгийн Заамар сумын цаг уурын “ЗААМАР” харуулын сүүлийн 10 жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь

тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. 2009-2019 оны агаарын жилийн дундаж температур $-0.7-2.3^{\circ}$ байна.

Хур тунадас: Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нутгийн хойд болон төв, өмнөд хэсгээр 50-58.0 мм, зүүн хэсгээр 60-55.0 мм байна. Хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 70-80 мм дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 80-100 мм нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Заамар сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны сарын дундаж хэмжээ 11.8-59.4 мм буюу хур тунадас багатай, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 11.8-60.0мм /6-8 сарын хооронд/ байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундаж орчим байна.

Хөрс, ургамал: Төсөл хэрэгжих бүс нутаг нь хөрс газар зүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж түүн дотор Хангайн мужид тус тус хамаарна. Ургамалжлын хувьд Уулын ойт хээр, хээрийн ургамалжил тархдаг онцлогтой. Нутгийн төв хэсгээр нам уулс, долгиорхог тал хөндий хослон тааралдах бөгөөд энд уулын хээрийн үндсэн төрхийг илэрхийлэгч хялгана, ботууль, алаг өвст, үетэнт хээр, нам хотос хөндийгөөр биелэг дааган сүүл – алаг өвс, жижиг үетэнт алаг өвст уулын хээр, харин чийг сайтай нам хотос хоолой, булаг шанд, гол горхи жижиг нуурын хөндийгөөр татмын нугын ургамалжил болох ширэг улалж, алаг өвс шивэлз зонхилсон цахидаг, улаантолгой, дэрст эвшил, хэвшилүүд түгээмэл тохиолдоно.

Хүн ам, эдийн засаг: Төв аймгийн Заамар сум нь хүн амын суурьшил ихтэй бүс нутагбөгөөд сумын хэмжээнд 3000 орчим хүн амтай. Халх ястан голлон амьдардаг. Голчлон газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг. Заамар уул уурхайн бүс нь зам харилцаа сайтай өвөл, зуны аль улиралд саадгүй аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Тухайлбал Хөтөлийн цементийн үйлдвэрээс 180 км, Дархан хотоос 200 км-т, Улаанбаатар хотоос 240 км-т оршдог. Тус суманд нэг 12 жилийн сургууль, нэг 10 жилийн сургууль, 2 цэцэрлэг, нэг МСҮТ, бүс дундын цагдаагийн газар, 2 хүн эмнэлэг, 150 сурагчийн багтаамжтай дотуур байр, 10 халуун ус, сауны газар, спорт болон урлаг заал тус тус 3, дэлгүүр 40, супермаркет 4, талх нарийн боовны цех болон оёдлын цех тус тус 2, 2 цахилгаан уурын зуух, банкны салбар, шуудан холбоо, Мобикомын станц, “Петровис”, “МТ” компаниудын ШТС-ууд үйл ажиллагаа явуулж байна.

4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2” төслийн ТЭЗҮ болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, БОНХСайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А 117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” ын дагуу тодорхойлов. Төсөл хэрэгжсэнээр MV-021068 тоот тусгай зөвшөөрлийн нийт 921.7 га талбайн /16%/ шууд нөлөөлөлд өртөнө.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Бага Хайлаастын доод хэсэг, Ар Наймганы хөндийн дунд хэсгийн баруун салаа Жалга-2” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино

4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн

бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Заамар Гоулд” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөө	№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар							
Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх Уулын ажлаас тоос босож орчны агаарын чанарыг муутгаад зогсохгүй уурхайд ажиллаж буй ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг хянах	1	Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх	Уурхайн, зам		2 000 000	Жил бүр 4-9 сард салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
	2	Тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг 20 км/цагаар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах.	Төслийн талбайд		2 000 000		
	3	Агаарын хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нөлөөллийн талбайд		ОХШ зардалд орсон	Жил бүр 9-р сар	
Нийт		4 000 000					
Усан чанар							
Усны нөөц, ашиглалт, усны бохирдол үүсэх	4	Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх.	2 000 000			Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
	5	Сав газартай ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөр төлөх					
	6	Ундны усны 1 худгийн тоолуурыг солих					
	7	Ус ашигласны төлбөрийг цаг тухайд төлөх Усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах, хяналт тавих	ҮА зардалд				
	8	Уст цэгүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийх	ОХШХ ийн зардалд орсон				
Нийт		2 000 000					
Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг							
Хөрс эвдрэлд орж, газрын тогтоц, хэлбэр, төрх	9	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	1 000 000			Жилд 1 удаа	MNS 5916:2008

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

өөрчлөгдөж, ухагдаж эвдэрнэ. Олон салаа зам гарснаас хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийн эрчим нэмэгдэнэ. Шимт хөрсний чанар муу байх нь нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	10	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах	Осол аваар гарч болзошгүй цэгүүд	–	2 500 000	2026 онд	MNS 5917:2008 MNS 5918:2008
	11	Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	Шимт хөрсний овоолго		4 000 000	Төслийн хугацаанд	
Нийт		6 500 000					
Амьтны аймаг							
Төслийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчныг удаан хугацаагаар хомсдуулах зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ	12	Лицензийн талбайн бүс рүү амьтан, орохыг хязгаарлах, хяналт тавих, хамгаалалтын хашаа барих, шаардлагатай газарт нөхөн сэргээлтийг хийх	Төслийн талбай түүний ойролцоо	Жил бүр	3 000 000	Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
Нийт				3 000 000			
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 15 500 000							

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ил уурхайн ашиглалтын явцад хөрс хуулалтаар их хэмжээний хоосон орон зай бүхий уурхай үүсдэг. Энэхүү ашиглагдсан хоосон орон зайг газрын гүний хурдас чулуулгийн дотоод овоолгоор олборлолтын ажилтай зэрэгцэн нөхөн дүүргэлт хийнэ. Ордыг 2-н жилийн хугацаанд ашиглах бөгөөд 1-2 дахь жилийн IV-р улиралд олборлолт явуулж дууссан хэсгүүдэд биологийн нөхөн сэргээлт, 2 дахь жилийн сүүлд хаалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Шимт хөрс хадгалан хамгаалах зардал	га	2.0	-	4 000 000	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”
2.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	5000	-	15 000 000	
	Нийт	19 000 000				

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Заамар Гоулд” ХХК нь 2026 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн 2.0 га газарт өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ.

Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	Сумын нутаг нөлөөлөлд өртөж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ	Нөхөн сэргээлт	га	2.0	-	13 410 000
Нийт		13 410 000				

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Заамар Гоулд” ХХК-ны талбайд явагдсан археологийн тандалт судалгаанд ямар нэгэн булш оршуулгын болон түүхийн дурсгал илрэн олдоогүй. Газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй. “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн заасны дагуу түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олдох буюу байх магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинжлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх үүрэгтэй. Уг үүргээ хэрэгжүүлэн ажиллана.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Алтны шороон орд олборлох, баяжуулах төслийн хүрээнд ямар нэгэн химийн бодис ашиглахгүй. Ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	1 000 000	Төслийн хугацаанд
2	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох	ҮА зардалд орсон	
3	Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах, Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах		
4	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах		
5	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх	500 000	
6	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	1 000 000	
7	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	ҮА зардалд орсон	
8	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургаалтанд хамруулах		
9	Жолооч бүрийг даатгалд хамруулах		
10	Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулах		
Нийт		2 500 000	

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна. Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав. - Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ. Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорх ус бохирдуулах сөрөг нөлөөтэй Шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хуванцар, шил, лаазыг тусад нь ангилан хадгалж, сумын хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх	1 000 000	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21-р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах			
		Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	2 000 000		
		Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох	6 000 000		
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах, дахин ашиглах			
		Автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх			
		Хаягдал дугуй дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх			
		Ахуйн бохир шингэн хаягдлыг хуримтлуулан бохир соруулах машинаар холбогдох газарт нийлүүлэх			
2.	Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан				
	Хаягдал техникийн тос, маслыг тусгай саванд хуримтлуулах				
	Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах				
	Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумтай гэрээ байгуулан зайлуулах				
	Нийт зардал 9 000 000				

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2026 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр 09-р сард хийгдэхээр төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээнийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Ажилчдын хотхон Уурхайн карьерь Уурхайн зам Уурхайн ухаж ачих процесс үед	09-р сард	4 цэгт 1 удаа	50 000	1 500 000	агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Агаар орчны бохирдол дуу чимээ,агаарын харьцангуй чийгшил	Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд шимт хөрсний овоолго Ажилчдын хотхон засварын талбай	09-р сард	4 цэгт 1 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 3 цэгт жилд 1 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг	2 000 000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	- MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, ахуйн хаягдал ус	09-р сард	4 цэгт 1 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ	2 000 000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ, Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995,
4.	Ургамлын зүйлийн бүрдлийн судалгаа	Тусгай зөвшөөрлийн талбай	09-р сард	1 удаа	-	2 110 000	Ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэц	Байгалийн ургамлын тухай хууль 1995.04.11 Ургамал хамгааллыг тухай 2007.11.15
	Нийт					7 610 000		

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2026 он	Хариуцсан албан тушаалтан
1	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	1 500 000	2 сард	Уурхайн дарга
2	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж үйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтанд хамруулах		Жилд нэг удаа	ХАБ
3	Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		10-р сараас 12-р сарын 1 нд багтаан	Уурхайн дарга, БОмэргэжилтэн
	Нийт	1 500 000		

**14. ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР
ХИЙГДЭХ АЖИЛ БОЛОН ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 9 БОМТ хэрэгжилт тайлагнах

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1.	Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	1 000 000	Жилд 1 удаа. Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Уурхайн дарга
	Нийт	1 000 000		

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021068 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 10. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	15 500.0
2	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	9 000.0
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2 500.0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	7 610.0
5	Удирдлага зохион байгуулалтын зардал	1 500.0
6	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр мод тарих	15 000.0
7	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	13 410.0
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	1 000.0
9	Нөхөн сэргээлтийн ажлын зардал/Шимт хөрс хадгалан хамгаалах зардал/	4 000.0
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	69 520.0

2026 онд тус төсөл нь хэрэгжихээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нийт 60,520,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2026.07.30-ны өдөр 14,200,000 төгрөг, 2026.08.05-ны өдөр 16,060,000 төгрөг, 2026.08.13-ны өдөр 4,500,000 төгрөг нийт 34,760,000 төгрөг байршуулсан болно.